## Монголын Уламжлал Шударга Ёсны Төлөө Намын 2000 оны УИХ-ын Сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр

Бүс нам нь УИХ-ын сонгуульд хууль тогтоох эрх мэдлийн цөөн мандатын төлөө өрсөлдөнө.
МУШЁНамын Бага Хурлаас тогтоосон доорхи зарчмуудыг мөрдөж ажиллана.
Үүнд:

1. Газрыг үл хувьчлуулах, Тусгаар тогтнол, Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулсан аливаа асуудалтай эрс тэмцэх.

2. МУШЁНамын дарга асан О.Дашбалбар агсаны "Газрын төлөө тулалдаан"нийтлэл бүтээл нь манай намаас газар өмчлөлийн асуудлаар явуулах бодлогын үндэс суурь юм.

3. Эгэл жирийн ард түмэн малчид , бизнес эрхлэгчидийн улс төр, эдийн засгийн эрх ашгийг тууштай хамгаалж тэдний зовлон жаргалын, УИХ дахь дуу хоолой болно.

4. Шударга ёсыг эрхэмлэх, түүнийг гажуудуулсан аливаа үзэгдэлтэй тууштай тэмцэнэ.

5. Монгол Улсад Монгол Улсын Иргэн хүн эзэн нь байх зарчмыг баримтлана.

6. Залуучууд өсвөр үеийнхэнийг эх оронч хүмүүжлээр хүмүүжүүлэх, тэднийг үндэсний бахархалтай болгох талаар төрөөс явуулах бодлогод нөлөөлж сургуулийн хичээлийн хөтөлбөрт "Эх орончдын түүх" нэртэй хичээлийг оруулна.

7. Монгол үндэстний оюун санааны үнэт зүйл болох нэгдмэл байдлыг бий болгох нь Үндэстэн улс төр эдийн засгийн талаар хүчирхэгжин хөгжихийн суурь гэж үзнэ.

8. Хуулийг дээдлэх, түүнийг хүндэтгэн дагаж мөрдөх нийт үндэстний нэгдмэл ухамсарыг буй болгох явдлыг энэ тэргүүний зорилт гэж үзнэ.

9. Монгол Улсыг Ерөнхийлөгчийн засаглал бүхий нэгдсэн хүчирхэг улс болно гэдэгт бид итгэдэг ба түүний төлөө тэмцэх нь ариун үүргээ гэж үзнэ.

Монголын Эв нэгдлийн намын үндэсний
зөвлөлийн 2000 оны 3 дугаар сарын
20-ны өдрийн хурлаар хэлэлцэн батлав.

# *"ЭВ НЭГДЭЛ, МОНГОЛ УЛСЫНХАА ТОЛӨӨ ЗҮТГЭЭ" БҮХ УЛС ТӨРИЙН ХҮЧИН, СОНГОГЧ ТҮМЭНД ХАНДАН ГАРГАХ "ЭХ ОРНӨО ХӨГЖҮҮЛЭХ" АЖНЛ ХЭРЭГЧ МӨРНИЙН ХӨТӨЛБӨР*

**2000-3-20** **Улаанбаатар хот**

## Нэгэн зүйл

## Гол хандлага

1. Аливаа улс төрийн хүчин болон бусдын үзэл бодлыг хүндэтгэн үзэж элдэв гүтгэлэг, дайралт давшилтыг үл гарган нэр төрөө эрхэмлэн сахиж, өв соёл, ёс заншлаа дээдлэн, улс орныхоо эв нэгдлийг бататган хамгаалж эх орноо гэсэн чин хүсэл эрмэлзэлтэйгээр ам ажлын нэгдлийг ханган, сайн бүхнийг дэмжин дэлгэрүүлж, саар болгоныг засч арилган, өнгөрсөн үеийн түүхийн дэвшилтэд ханамжлалыг хөгжүүлэн, орчин үеийн зах зээлийн харилцаанд нийцүүлж ажиллахад анхаарлаа төвлөрүүлэхийг чухалчилна.

2. Хэт туйлширал, алсын хараагүй харалган бодол, зах зээлийн эдийн засгийн харилцааны сөрөг үр дагавар элдэв луйвар, хоцрогдол, ялзрал бүхнийг ахмадуудынхаа алтан сургаальд түшиглэн, харьцангуй өндөр боловсрол, мэргэжил, ажлын чадвар, авхаалж самбаа сайтай шилдэг туршлагатай боловсон хүчнийхээ ширгэшгүй ундармал, нөхцлийн хүчээр даван туулна.

3. Гадаадыхныг хэт шүтэн улс үндэстнийхээ нэр төр, эрх ашгийг хохироож чихнээ яруу сонсогдох аялгуут монгол хэлээ саармагжуулан улмаар дэлхийд гайхагддаг хөдөлмөрч чанараа алдан, хийж чаддаг байсан нөөц бололцоо болгоноо үгүйсгэсэн явуургүй хандлагаас ангижрах арга хэмжээг авна.

4. Сонгогчдынхоо төлөөлөлийг өргөтгөх замаар үр дүн, үр ашгаар тааруухан шрлага ихтэй ажилладаг УИХ-ын одоогийн тогтолцоог өөрчилж 1000 депутаттай орон тооны АИХ, 25 гишүүнтэй УБХ-тай болгох үндсийг судлан шийдвэрлэнэ.

5. Монголын засаг захиргааны аймагчилсан ба сумчилсан одоогийн тогтолцоог эргэн харж 5 бүсэд хамруулан мужлалын бодлогыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- **Баруун мужид** хамаарагдах Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай аймгууд нь ой мод багатай, уулархаг төвөөс алслагдмал тул эрчим хүч, тээвэр шатахууны бэрхшээлтэй байдгийг бодолцон малын болон хээр талын бэлчээр усны нөөц, хүн амын эртний суурьшмал онцлог түүхэн туршлагыг нь харгалзан Ховдын УБДС-ийг УБИС болгон өргөтгөж, ХАА-н техникумыг ХААДС-аар өөрчилж Завханы аймгийн соёлын коллежийг Соёл урлагийн дээд сургуулиар сольж, Говь-Алтайд хэвлэл мэдээлэлийн дээд сургуулийг байгуулна.

Мөн Увс аймагт АУИС, ТИС-ийн, Баян-Өлгийд цагдаагийн академийн салбарыг нээн хөгжүүлж, нийгмийн бодлогын асуудлыг нь шийдвэрлэн алс холын нутаг сурагчдын боловсрол мэргэжил эзэмших сонирхол хэрэгцээг сайжруулан орон нутгийн үндэсний боловсон хүчнээр тасралтгүй хангах нөхцлийг бүрэлдүүлнэ. Аялал жуулчлалын шинэ чиглэлийг тогтоон хөгжүүлнэ. Түүнчлэн гурил тэжээлийн болон мод боловсруулах үйлдвэрийн материаллаг баазын нөөцөд нь түшиглэн үндэсний үйлдвэрлэлийг бүх талаар дэмжин тусалж хөгжүүлнэ.

- **Хойт мужид** хамрагдах Хөвсгөл, Булган, Архангай, Орхон аймгуудад аялал жуулчлалын бааэыг хөгжүүлэн, Архангайд УБИС, Орхонд ТИС, Булганд ХЗДС, Хөвсгөлд АУИС-ийн салбарыг байгуулан бүс нутгийн онцлогийг харгалзан мах, сүү цагаан идээний үйлдвэр, жимс жимсгэний болон төмс хүнсний ногооны сервийн үйлдвэрийг нээн ажиллуулна.

- **Төвийн мужид** багтах Улаанбаатар, Өвөрхангай, Дархан, Төв, Сэлэнгэ аймагт үр тариа, төмс хүнсний ногооны үйлдвэрийг дагнуулан хөгжүүлж барилгажилт, зорчигч ба ачаа тээвэрлэлтийг өрнүүлэн худалдаа эдийн засгийн чадвар бүсийг нээн ажиллуулна.

- **Өмнөт мужид** орох Говьсүмбэр, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дорноговьд тэмээ, ямааны ноос ноолуур боловсруулах болон шахмал хатуу түлшний жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэн дулааны цахилгаан станц барьж ашиглах ба олон улсын аялал жуулчлалын төвийг Өмнөговьд нээн улмаар өрөмдмөл уурхай, хүдэрлэгийг сэргээн хэрэглэж, Өмнөговьд менежментийн дээд сургууль нээх, Дорноговийн АУДуС-ийг АУИС-н салбар болгон өргөтгөж дээд сургууль болгох, Дундговийн ХАА-н техникумыг ХААИС-ийн салбарт шилжүүлэн дээд сургууль сэлбэрээр хичээллүүлэх, Өвөрхангайд ТИС-ийн бааз газрыг байгуулах гэх мэт асуудлыг дэвшүүлэн тавьж, Говьсүмбэрт олон улсын худалдааны төвийг нээн ажиллуулна.

- **Дорнот мужид** хамрах Дорнот, Сүхбаатар, Хэнтий аймгууд нь алсын зонгомол ирээдүйтэй байдаг онцлогийг иш үндэс болгон Хэнтийд Чингис хааны онгон байгуулж, АУИС-ийн салбар, Дорнотод ТИС-ийн, Сүхбаатарт МУИС-ийн салбарыг нээн хичээлүүлж, уул уурхай, барилгын материалын үйлдвэрийн салбаруудыг голлон хөгжүүлнэ.

Эх орны нийслэл Улаанбаатар хотын засаг захиргааны давхардалтын бүтцийг үндсээр нь өөрчилж дүүрэггүй болгон нийслэлийн засаг даргын тамгын газрын орон тоо зохион байгуулалтыг эрс хямдруулан хороодын эрх хэмжээг өргөтгөн хот хороо гэсэн засаг захиргааны нэгжийн удирдлагатай болгон завсрын шат дамжлагыг арилгая. НА.

**Нэгэн зүйл:**

**Зах зээлийн эдийн засгийн харилцааны чиглэл**

1. Улс төрийн албан тушаалтан, шүүгч, лиценз олгогчдод зөвшөөрөгдөх эрхийг өргөтгөхийн зэрэгцээ хүлээх үүрэг хариуцлагыг хатуу чангатган эдийн засгийн уян хатан бодлого боловсруулж мөрдөнө.

2. Төсвийн байгууллагад ажиллагсдын нийгмийн баталгааг найдвартай болгож, аж ахуйн тооцоонд шилжүүлэн цалинг 300 ам доллараас доошгүйд хүргэж

[illegible] ачаалалыг нь ихэсгэн орон тоог цомхотгон, улсын татаасгүй ажилладаг [illegible]ийг бүрдүүлнэ.

3. Улсын мал мах бэлтгэл, ургац хадлангийн компанит ажил, оюутан [illegible]ргчдын зун, намрын ажил, субботникийн үр өгөөжтэй дэвшилтэд арга барилыг [illegible]тнаас улсын нөөц алдагдан, нийтийн эзэмшлийн эд хогшил эзэнгүйдэн сүйрч [illegible]лгэн зардал чирэгдэл даамжирч буйг засч, хуучинсаг гэлгүйгээр эдгээр [illegible]амжлалт ажлын бүтээлч арга барилыг хөгжүүлнэ.

4. Хилийн цэргийн бүх анги, нэгтгэл, отряд, суманг мал аж ахуйн газар [illegible]риалантай болгох ажлыг шуурхай зохион байгуулж хүнснийхээ хэрэгцээг өөрсдөө [illegible]гадаг аж ахуйн тооцоонд шилжүүлнэ.

5. Өнгөрсөн хугацаанд хувьчлагдсан объектуудын зориулалтыг шалган улсын [illegible] явуулан аттестатчилж аж ахуйн байгууллагын ажлын чанарын зэрэглэл [illegible]тоон тухайн объект хувьчлагдахаасаа өмнө хэдий хэмжээний татвар төлж [illegible]йсныг хянан үзэж хэрэв уг татвараас бага татвар улсад өгч байсан нь тогтоогдвол [illegible]хон төлүүлж шууд дахин хувьчлах арга хэмжээг авна.

6. МАА-н түүхий эдийн захыг суурин газраас сумын төв рүү шилжүүлэн [illegible]вийн худалдаачдын очдог төв болгоно.

7. Мал болон малчдыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах арга хэмжээг цаг [illegible]лгүй авч тэдгээрийн үр хүүхдийг үнэ төлбөргүй сургалтад хамруулна.

8. Цаг үеийн болон шуурхай ажлын дайчилгааг ажилгүй хүмүүс, хууль дүрэм [illegible]рчигчид, жижгээр танхайрагчид, эрүүлжүүлэхэд орогчдыг хамруулан хийж төв [illegible]уурин газрын газар шорооны ажил, хот орчин тохижилт, байгалийн гамшгийг [illegible]рилгах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, аривч, хямгач, аж ахуйч ажиллагааг бүх [illegible]газарт өрнүүлнэ.

9. Ядуу хүмүүсийн эгнээнд орохыг хүсэгч, зохиомол аргатангуудын гарцыг [illegible]ааж, хөдөлмөрийн чадварын тогтоолт хийн, нийтийг хамарсан ажилд хамруулан [illegible]дийн засгийн хувьд ашигтай ажиллах бодлого баримтлана.

10. Жилд дундчаар 52-76-аас доошгүй удаа хийгддэг их, бага наадмууд баяр [illegible]лолын үйл ажиллагааг цэгцлэн хуулиар зохицуулж наадамд зарцуулдаг хөрөнгийн [illegible]йдалд төрийн болон төрийн бус байгууллагуудын үзлэг шалгалтыг явуулан [illegible]өрөнгө хандивлалтын байдал, хэт баярхан тансагладаг явдлыг зогсоон их [illegible]эмжээний хөрөнгийг үрэлгэн зарцуулдаг одоогийн арга барилыг үндсээр нь [illegible]өөрчлөн эдийн засгаа эрүүлжүүлэн тогтвортой хөгжүүлнэ.

11. Өмнөх жилүүдэд гарсан 5 сая хүртэл төгрөгийн өртэй ард иргэдийг өрийн [illegible]үлжээнээс нэг удаа чөлөөлж, ахуй амьдралдаа ухаалаг хандах бололцоо олгоход нь [illegible]услана.

12. Үндэсний үйлдвэрүүдийг сэргээн хөгжүүлж монгол хэв маягийн менежментийн үйл ажиллагааг гол болгон олон улсын стандартад тохирсон [illegible]гтгэгдэхүүн үйлдвэрлэн, байгаль орчныг зах зээлийн харилцааны буруу үр [illegible]гавараар сүйтгэж буй үрэлгэн байдлыг арилгахын төлөө ажиллана.

13. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг дотооддоо боловсруулах жижиг, дунд [illegible]йлдвэрүүдийг нэмэгдүүлж хүнсний аюулгүй байдлыг хангасан цэвэр бүтээгдэхүүн [illegible]йлдвэрлэдэг болгоно.

## Нэгэн зүйл:

### Хүн амын эрүүл мэнд, нийгмийн бодлого

1. Ахмадууд, нялх хүүхэд, хүндэт донорууд ыг үнэ төлбөргүй эмнэлгийн үйлчилгээгээр хангаж ажиллана.

2. Хүн амын эрүүл мэндийн сайн сайхны төлөөх буянт үйлсийг хөхүүлэн урамшуулж буяны өглөгийн ач холбогдлоор нь татвараас 1-3 жил хүртэл хугацаагаар чөлөөлнө.

3. Төлбөртэй эмчилгээний байдалд олон нийтийн үзлэг хийж чанарын хяналт тогтоон тодорхой хугацаанд аттестатчилан эм, эмийн бус эмчилгээ, үйлчилгээний нь үр дүнтэй харьцуулдаг арга барилыг бүх төрлийн эмнэлгүүдэд нэвтрүүлнэ.

4. Монгол хэл, монголын түүх, соёл урлагийн хичээлийг бүх шатны аль ч сургуулиудад заавал заалган эх оронч үзэл хүмүүжлийг оюутан, сурагчдад төлөвшүүлэх арга хэмжээг авна.

5. Хэвлэл, мэдээлэлийн хэрэгслэлийн сурталчилгаа, нийтлэл нэвтрүүлгийн бодлогыг цэгцтэй болгон улсын нууц, хэрэг учралын байдалтай холбогдсон буруу ташаа ойлголт төрүүлж, гэмт хэрэг зөрчил гаргах гарцыг заадаг төдийгүй жирийн иргэний нэр төрийг дайрч доромжлон гутаан гүжирддэг, хүний эрх ашгийг хохироогч баримт нотолгоогүй мэдээлэл цацдаг арга барилыг бүрмөсөн арилгах шийдвэртэй арга хэмжээг авна.

6. АНУ, БНСУ, Австрали, Герман гэх мэтийн гадаадын орны туршлагыг бүтээлчээр нэвтрүүлж өөрийн оронд сурах буюу ажиллахаар ирэгч гадаадын иргэдэд тавих хяналтыг хүчтэй болгон хөрөнгийн баталгаат батламжаар ажиллаж амьдардаг бо дэгийг нэгэн адил авч хэрэгжүүлье.

7. Аймаг, нийслэл, сумдын газар олголтын байдалд улсын үзлэг явуулж аттестатчилан монгол хүний нэрээр газар авч байдаг гадаадын иргэний эзэмшиж буй газрыг хураан, нэн ядмаг амьдралтай хүмүүст буюу ажил хэрэгч бүтээлч, өөрийн эх орны иргэдэд өгч туслана.

8. Соёл урлагийн хувьд чанаргүй кино бүтээдэг, шаардлага хангаагүй тоглолт хийдэг, их урлаг, үндэсний бахархал урлаг соёлын залгамж чанарыг алдагдуулдаг, чанаргүй зохиолч яруу найрагч олширсон зэрэг гаж буруу үзэгдлийг таслан зогсоож чадвар ёсны шаардлагад нь нийцүүлж ажилладаг тодорхой алхмыг хийнэ.

9. Өмч хувьчлалын алдаатай бодлогоор хохирсон үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллагын ажилтан ажиллагсдын хохирлыг нөхөн барагдуулах ажлыг эрчимтэй хийж хууль хяналтын байгууллагын шалгалт явуулан шаардлагатай гэж үзвэл тухайн байгууллагыг анхных нь нөхцлөөр сэргээн ажилуулах арга хэмжээг хэрэглэнэ.

10. Нийслэл болон төв суурин газруудын орон сууц хувьчлалаар огт хамааралгүй үлдсэн гэр хорооллолын оршин суугчдад сууц хувьчлалын дундач үнэтэй тэнцэх хөрөнгийн эх үүсвэрийг тогтоон ямар хэлбэр, нөхцлөөр эргүүлж олгож болохыг шийдвэрлэн, сууц өмчлөлийн алдаатай бодлогыг цэгцлэн хор уршгий нь арилгана.

11. Спортын болон үндэсний хэмжээний уралдаан тэмцээний бай шагналын гол бус хэмжээг өөрчлөхийн зэрэгцээ хурдан морь унасан балчирхан үрс унасан мориныхоо үнээс долоон дор үнэлэгдэн шагнагддагыг болиулж, уяачтай адил шагналтай болгон тамирчид, бөхчүүд, сурчид, уяачид, хурдан морины хүүхэд морьд, машин техник, холбогдох хэрэгслэлийг нийгмийн даатгалд хамруулан аливаа хохирлыг нөхөн барагдуулдаг хэвшлийг тогтооно.

12. Монголын хэрэглэгчдийн найдвартай түнш, анд нөхөр, цолтон, оюуны өмчийн патенттэй байгууллага, хүмүүсийн нарийн үнэлэмжийг дээшлүүлэн гаргарын хөнгөлөлт үзүүлэн дэмжлэг туслалцааны бодит нохцлөор хангаж ажиллана.

13. Цаг үеийн байдал хууль ёс сурталчлан таниулах 7 хоногийн тойм цагийг бүх газарт нэвтрүүлж хэрэгжүүлнэ.

14. Хүн амд цусны шинжилгээ явуулан урьдчилан сэргийлэх тарилга хийдэг байсан оновчтой арга барилыг сэргээн хөгжүүлнэ.

15. Зуны улиралд ямар ч ашиглалтгүй болдог аймаг, нийслэл, сумдын нэцэрлэг, бүх шатны сургуулийн барилгын ашиглалтыг сайжруулан цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлж, зуны өдрийн зуслан, хөдөлмөр амралтын өдөрлөг, семинар цугларалтыг зөхион байгуулах ажлыг тууштай хэрэгжүүлнэ.

16. Өвлийн улирлын их ачаалалын даацыг тохируулах үүднээс оюутан, сурагчдыг өвөлд 2 сар амруулан малчид, төлчдөд туслах ажлыг зохион байгуулж, зуны амралтын хугацааг 1 сар болгон, намрын хадлан, ургац хураалтын бэлтгэл ажлын чанарыг дээшлүүлэх замаар оюутан, сурагчдын бие бялдарын хүмүүжлийг сайжруулах ажлыг зохиөн байгуулна.

17. Хонхны баярыг хавар хийдэг бүдүүлэг арга барилыг үндсээр нь өөрчилж жил бүрийн 9-р сарын 01-нд элсэгчийн шинэ жилийн нээлтээр хийдэг уламжлалыг тогтооно.

18. Төрт ёсны галын тахилгыг жил бүрийн цагаан сараар хийдэг дэвшилтэд уламжлалыг нэвтрүүлнэ.

19. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх үүднээс дэвсгэрийн албан байгууллага, айл өрх бүр 50 м$^2$ талбайг засч тохижуулан хоггүй хот болох ажлыг байнга хийлгэж, илэрсэн зөрчлийг торгуулийн системээр зохицуулан хог түүгчидгүй орчинг бүрдүүлнэ.

20. Их, дээд сургуульд 2 жил дараалан онц суралцсан оюутны сургалтын төлбөрийг 50 хувиар, 3 жил дараалан онц суралцсан оюутны сургалтын төлбөрийг 75 хувиар, 4 жил дараалан онц суралцсан оюутны сургалтын төлбөрийг 100 хувиар чөлөөлж мэдлэг боловсролтой шилдэг тэргүүний оюутан залуусын эгнээг өргөтгөнө.

21. Ахмад өндөр настны талаар төр засгаас авах арга хэмжээг идэвхжүүлэн тэдгээрт сүү, тараг, талхыг үнэгүй олгодог сонгодог хувилбарыг нэвтрүүлж амьдралд нэвтрүүлнэ.

22. Хүүхдийн хөдөлмөрлөх эрхийн тухай хуулийг яаралтай боловсруулан оргөн олон нийтийн хэлэлцүүлэг явуулж, тэдгээрийг нийгмийн тустай ходөлмөрт зөв зохион байгуулалтайгаар хамруулах ажлыг зохион байгуулна.

23. Залуу гэр бүлийг төлөвшүүлэхэд анхаарч "Ховгүүд" арга хэмжээг зохион мэдлэг боловсрол, ажил мэргэжил, ажил хэрэгч чанар, зан харьцаа, хувийн соёл,

сайр халамж, амьдрах ухаан зэргийнхээ сул талаараа охидод гологддог түгээмэл хүчирхийлэлд арилган охидоос нийт хуримлагчдын 10 гаруй хувь нь гадаадын иргэдтэй гэрлэдэг болсон шалтгаан нөхцлийг судална.

24. Монгол хэлний соёл түүний агуулгын арвин баялаг хэлбэр, утга яруу удамжлалт аргачлал, тод сайхан халдашгүй байх дархан эрхийг зөрчин бусармаг бөгөөд бүдүүлэг зэрлэг балмад үг хэллэгээр дууны үг зохиох, телевиз, радиогоор олон ярилцлага явуулан өөрсдийгөө "Од" хэмээн тооцогчдын ёс бус үйл ажиллагааг таслан зогсооно.

25. Аймаг, нийслэлийн төв суурин газрын реклам чимэглэлийн алдаатай бодлого, хаягжуулалтыг олон янзын хэлээр ойлгомж муутай алдаатай хийдэг, гоо үзэмжээр тааруухан, үндэснийхээ өвөрмөц онцлогийг үгүйсгэсэн хандлагыг үндсээр нь өөрчлөнө.

26. Хувийн аж ахуйн нэгж байгууллагуудад ҮЭ-ийн бүлгийг байгуулан үйл ажиллагааг нь тогтмолжуулж хөдөлмөр хамгаалал, техник аюулгүйн ажиллагааны шаардлагыг мөрдүүлэн ажилтан, ажиллагсдын эрх ашгийг хохироож байгаа одоогийн ажил хэрэгч, шударга дайчин биш байдлыг эрс өөрчлөн шинэчлэлт хийж хүмүүсийн нийгмийн баталгааг хангаж ажиллана.

***МОНГОЛЫН ЭВ НЭГДЛИЙН НАМ***